



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2024.02.05

№ 05

Улаанбаатар хот

### “Төрийн банк” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 73 дугаар зүйлийн 73.11 дэх хэсэг, 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дэх заалт, “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтын Тооллогын комиссын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “дагуу” гэсний дараа “батлагдсан Хяналтын зөвлөлийн ажиллах журамд заасан нөхцөл, шаардлагыг баримтлан” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалтын “эзэмшдэггүй” гэсний дараа “иргэн” гэж тус тус нэмсүгэй.

2. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн дараах зүйлийн хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 9 дүгээр зүйлийн 9.5.2 дахь заалт:

“9.5.2.Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь банктай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан худалдан авах ажиллагааны харилцаа, хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;”

2/ 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсэг:

“10.9.ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон бүх гишүүд өөрсдийн гаргасан саналаа баталгаажуулан гарын үсэг зурах бөгөөд хурлаар хэлэлцсэн асуудалд эсрэг саналтай байсан гишүүн энэ тухайгаа тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурна.”

3/ 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг:

“22.1. Банкны эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, захирлуудын зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирлын дэргэдэх хороодын саналын эрхтэй дарга, гишүүн хамаарна.”

3. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “6 (зургаа)” гэснийг “5 (тав)” гэж, “3 (гурав)” гэснийг “4 (дөрөв)” гэж тус тус өөрчилсүгэй.

4. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн “ээлжит” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “ердийн” гэснийг тус тус хассугай.

5. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын эчнээ санал хураалтаар гаргасан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад, нээлттэй мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д үүрэг болгосугай.

6. Эчнээ санал хураалтаар “Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д үүрэг болгосугай.

7. “Төрийн банк” ХК-ийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт Улсын бүртгэлд бүртгэгдсэн даруйд “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д заасан шалгуурыг хангасан этгээдийг сонгон шалгаруулах ажиллагааг ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэн, хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

8. “Төрийн банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний бие даасан, хараат бус, мэргэшсэн байх зарчмыг баримтлахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН